



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/50/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 99890393 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ГЭР БҮЛ, Г
ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Н.МЭНДБАЯР
ТАНАА

2021.02.25 № 2/167

танай _____-ны № _____-т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

• 005020196

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>50,104,432.18</u>	<u>164,914,424.69</u>
33	АВЛАГА	00.00	49,900,000.00
335	Бусад авлага	00.00	49,900,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	49,900,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,104,432.18	115,014,424.69
351	Түүхий эд материал	2,794,000.00	3,437,500.00
35110	Тусгай зориулалттай материал	2,741,000.00	2,891,000.00
35130	Эм боох материал	53,000.00	546,500.00
354	Хангамжийн материал	47,310,432.18	111,576,924.69
35410	Бичиг хэргийн материал	3,260,529.00	2,233,969.00
35420	Аж ахуйн материал	14,688,303.18	14,597,703.18
35430	Сэлбэг хэрэгсэл	63,000.00	63,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,113,052.51
35470	Бусад хангамжийн материал	29,298,600.00	93,569,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>323,062,833.05</u>	<u>323,769,675.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	323,062,833.05	323,769,675.68
392	Биет хөрөнгө	269,504,083.24	269,944,675.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	173,103,726.83	173,103,726.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,752,221.92	-11,126,668.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,995,000.00	34,965,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,002,406.66	-3,372,583.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,747,453.00	85,730,253.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70,218,029.89	-80,092,296.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,011,781.45	76,186,781.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,072,081.57	-38,478,673.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,925,445.00	36,925,445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,399,550.00	-5,061,276.36
39217	Ном	1,164,967.00	1,164,967.00
393	Биет бус хөрөнгө	53,558,749.81	53,825,000.00
39301	Програм хангамж	625,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-616,250.19	-625,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	53,550,000.00	53,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>373,167,265.23</u>	<u>488,684,100.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,283,450.00</u>	<u>30,107.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,283,450.00	30,107.00
413	Өглөг	1,283,450.00	30,107.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,239,950.00	-00.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	30,107.00
4136	Бусад өглөг	43,500.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	43,500.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>371,883,815.23</u>	<u>488,653,993.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	371,883,815.23	488,653,993.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	94,718,933.00	94,718,933.00
51101	Өмч: - төрийн	94,718,933.00	94,718,933.00
512	Хуримтлагдсан үр дүн	110,254,385.72	227,024,563.87

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	110,254,385.72	110,254,385.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	116,770,178.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,910,496.51	166,910,496.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	373,167,265.23	488,684,100.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	680,153,861.00	826,232,515.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,523,305.00	26,276,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,523,305.00	26,276,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,523,305.00	26,276,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,523,305.00	26,269,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,682,356.00	165,450,215.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	496,948,200.00	634,506,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133,639,056.00	151,406,915.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	16,733,343.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,563,356.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,075,700.00	134,673,572.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,043,300.00	14,043,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,043,300.00	14,043,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	636,975,970.51	706,481,576.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,975,970.51	706,481,576.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,264,063.51	684,477,062.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,756,744.00	131,316,697.16
210101	Үндсэн цалин	97,756,744.00	131,316,697.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,140,274.00	22,102,278.92
210201	Тэтгэврийн даатгал	12,077,618.00	15,355,374.05
210202	Тэтгэмжийн даатгал	787,263.00	1,819,879.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	558,133.00	1,270,209.38
210204	Ажилгүйдлийн даатгал	200,330.00	332,435.81
210205	Эрүүл мэндийн даатгал	1,516,930.00	3,324,379.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,389,481.00	12,325,011.00
210301	Гэрэл, цахилгаан	1,338,125.00	1,209,531.00
210302	Түлш, халаалт	10,224,476.00	10,729,920.00
210303	Цэвэр, бохир ус	826,880.00	385,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,019,587.76	6,529,247.30
210401	Бичиг хэрэг	3,184,170.00	3,626,260.00
210402	Тээвэр, шатахуун	728,508.76	1,172,880.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,106,909.00	1,530,107.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	343,300.00	00.00
210604	Урсгал засвар	343,300.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	207,000.00	267,000.00

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	207,000.00	267,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,448,032.25	479,306,631.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,448,032.25	478,706,831.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	49,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	238,000.00
210807	Газрын төлбөр	00.00	62,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,959,644.50	32,630,197.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,820,000.00	2,915,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,139,644.50	29,715,197.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	711,907.00	22,004,513.92
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,943,042.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,943,042.92
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	330,135.00	18,061,471.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	329,559.00	00.00
213404	Хөрөнгийн	576.00	18,061,471.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	381,772.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	381,772.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	43,177,890.49	119,750,938.15
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,980,760.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,980,760.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,980,760.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	43,177,890.49	116,770,178.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	644,860,424.00	799,963,515.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	7,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	7,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	7,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	7,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	644,860,424.00	799,956,215.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	496,948,200.00	634,506,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	133,639,056.00	151,406,915.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	16,733,343.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,563,356.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,075,700.00	134,673,572.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,043,300.00	14,043,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,043,300.00	14,043,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,229,868.00	00.00

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,229,868.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	622,830,424.01	791,530,715.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	622,830,424.01	791,530,715.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620,288,849.01	768,936,271.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,099,997.00	132,572,847.00
210101	Үндсэн цалин	98,099,997.00	105,297,406.00
210102	Нэмэгдэл	00.00	27,275,441.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,570,000.00	16,099,066.08
210201	Тэтгэврийн даатгал	7,867,600.00	10,836,292.04
210202	Тэтгэмжийн даатгал	925,600.00	1,315,695.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	740,500.00	1,052,555.81
210204	Ажилгүйдлийн даатгал	185,100.00	263,135.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,851,200.00	2,631,388.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,370,441.00	12,325,011.00
210301	Гэрэл, цахилгаан	1,338,125.00	1,209,531.00
210302	Түлш, халаалт	10,224,476.00	10,729,920.00
210303	Цэвэр, бохир ус	807,840.00	385,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,890,009.00	6,107,300.00
210401	Бичиг хэрэг	1,380,400.00	2,507,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,402,700.00	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,106,909.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	343,300.00	00.00
210604	Урсгал засвар	343,300.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	405,000.00	558,500.00
210702	Дотоод албан томилолт	405,000.00	558,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	490,390,102.01	597,983,547.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,390,102.01	597,423,747.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	49,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	210,000.00
210807	Газрын төлбөр	00.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,220,000.00	3,290,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,220,000.00	3,290,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,541,575.00	22,594,443.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,829,668.00	589,930.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,229,868.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	599,800.00	589,930.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,943,042.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,943,042.92
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	330,135.00	18,061,471.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	329,559.00	00.00
213404	Хөрөнгийн	576.00	18,061,471.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	381,772.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	381,772.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,029,999.99	8,432,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,030,000.00	8,432,800.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,030,000.00	8,432,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,030,000.00	8,432,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,030,000.00	8,432,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,030,000.00	-8,432,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	67,076,495.23	328,705,924.74
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	67,076,495.23	328,705,924.74
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	43,177,890.49	43,177,890.49
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	110,254,385.72	371,883,815.23
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	110,254,385.72	371,883,815.23
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	110,254,385.72	371,883,815.23
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	116,770,178.15	116,770,178.15
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	94,718,933.00	166,910,496.51	227,024,563.87	488,653,993.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	648,549,300.00	644,606,257.08	3,943,042.92	99.4
УРСГАЛ ЗАРДАЛ	648,549,300.00	644,606,257.08	3,943,042.92	99.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,949,300.00	644,016,327.08	3,932,972.92	99.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,708,000.00	132,572,847.00	135,153.00	99.9
Үндсэн цалин	107,417,100.00	105,297,406.00	2,119,694.00	98.0
Нэмэгдэл	25,290,900.00	27,275,441.00	(1,984,541.00)	107.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,915,700.00	16,099,066.08	1,816,633.92	89.9
Тэтгэврийн даатгал	12,607,300.00	10,836,292.04	1,771,007.96	86.0
Тэтгэмжийн даатгал	1,327,100.00	1,315,695.01	11,404.99	99.1
ҮОМШӨ-ний даатгал	1,061,700.00	1,052,555.81	9,144.19	99.1

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажилгүйдлийн даатгал	265,400.00	263,135.20	2,264.80	99.1
Эрүүл мэндийн даатгал	2,654,200.00	2,631,388.02	22,811.98	99.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,325,200.00	12,325,011.00	189.00	100.0
Гэрэл, цахилгаан	1,209,600.00	1,209,531.00	69.00	100.0
Түлш, халаалт	10,730,000.00	10,729,920.00	80.00	100.0
Цэвэр, бохир ус	385,600.00	385,560.00	40.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	6,100,000.00	6,100,000.00	-	100.0
Бичиг хэрэг	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	2,400,000.00	2,400,000.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,718,100.00	00.00	1,718,100.00	-
Урсгал засвар	1,718,100.00	00.00	1,718,100.00	-
Томилолт, зочны зардал	563,500.00	558,500.00	5,000.00	99.1
Дотоод албан томилолт	563,500.00	558,500.00	5,000.00	99.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	473,327,100.00	473,070,903.00	256,197.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	472,647,300.00	472,511,103.00	136,197.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	75,000.00	00.00	75,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	49,800.00	49,800.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	00.00	45,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,000.00	210,000.00	-	100.0
Газрын төлбөр	50,000.00	50,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3291700.00	3290000.00	1,700.00	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,291,700.00	3,290,000.00	1,700.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600000.00	589930.00	10,070.00	98.3
Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	589,930.00	10,070.00	98.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	589,930.00	10,070.00	98.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	648,549,300.00	644,615,257.08	3,934,042.92	99.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	634,506,000.00	632,290,246.08	2,215,753.92	99.7

Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	634,506,000.00	632,290,246.08	2,215,753.92	99.7
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,043,300.00	12,325,011.00	1,718,289.00	87.8
Орон нутгийн төсвөөс	14,043,300.00	12,325,011.00	1,718,289.00	87.8
АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18	-	100.0
Удирдах ажилтан	01	01	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	07	07	-	100.0
Үйлчлэх ажилтан	04	04	-	100.0
Гэрээт ажилтан	06	06	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	133,345,444.00
УРСГАЛ ЗАРДАЛ	0	133,345,444.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	133,345,444.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	133,345,444.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	133,345,444.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	133,345,444.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0	133,345,444.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	16,733,343.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	116,612,101.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Н.Мэндбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 11-ээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг ирүүлээгүй байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд хамгаалал өв тэгш хүмүүжлийн болон Гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж тэднийг хөгжих таатай орчин бий болгоход оршино.” гэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж 5579.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10 төрлийн зөвлөмж өгсөн байна. 2020 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 475691.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9513.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 706481.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14129.6 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 488684.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 115516.8 мянган төгрөгөөр буюу 30.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,104.4	164,914.4	114,810.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	49,900.0	49,900.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	50,104.4	115,014.4	64,910.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	323,062.8	323,769.7	706.8
Үндсэн хөрөнгө	450,123.4	462,526.2	12,402.8
Хуримтлагдсан элэгдэл	(127,060.5)	(138,756.5)	(11,696.0)
Нийт хөрөнгө	373,167.3	488,684.1	115,516.8
Өр төлбөр	1,283.5	30.1	(1,253.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	371,883.8	488,654.0	116,770.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	373,167.3	488,684.1	115,516.8

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд авлагагүй байсан бөгөөд тайлант онд 49900.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна. Оны эхэнд 1283.4 мянган төгрөгийн өглөгтэй, оны эцэст 30.1 мянган төгрөгийн өглөгтэй байна. 49900.0 мянган төгрөгийн авлага нь 2020 оны төсөвт Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн тохижилт, тоног төхөөрөмж, тавилга авахаар батлагдсан бөгөөд тендер зарлагдаж, шалгарсан Ямаат өндөр хайрхан ХХК нь хөрөнгийг онд нь багтааж нийлүүлээгүй байхад гэрээний дагуу санхүүжилтийг 100 хувь олгосныг авлагаар бүртгэсэн байна.

Өмнөх онд 1283.5 мянган төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд оны эцэст 30.1 мянган төгрөг болж 1253.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115014.4 мянган төгрөг болж 64910.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материал 64270.6 мянга, түлш шатах тослох материал 1113.0 мянга, тусгай зориулалтын материал 150.0 мянга, эм боох материал 493.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бичиг хэргийн материал 1026.5 мянга, аж ахуйн материал 90.0 мянган төгрөгөөр тус тус мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бусад хангамжийн материал 64270.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НҮБ-ын санхүүжилтээр авсан “Хамтдаа шийдье” төслийн хүрээнд 16000 өрхөд сургалт сурталчилгааны материал 46400,0 мянган төгрөг $\frac{2.9 \text{ мян. төг} * 16000 \text{ өрх} = 46400.0 \text{ мян. төг}}{}$, орон гэргүй болсон зорилтот бүлгийн гэр бүлд 3 гэр 7980,0 мянган $\frac{3 \text{ гэр} * 2660, \text{ мянга} = 7980.0 \text{ мянган}}{}$

мянга/ төгрөгөөр худалдан худалдан авсан боловч тайланд онд зарцуулаагүй үлдэгдэлтэй байгаа нь голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 462526.2 мянган төгрөг болж 12402.8 мянган төгрөгөөр өссөн нь тээврийн хэрэгсэл 3970.0 мянга, машин тоног төхөөрөмж 3982.8 мянга, тавилга эд хогшил 4175.0 мянга, программ хангамж 275.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгийг бүртгэлд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 2020 онд төсвийн хөрөнгөөр тээврийн хэрэгсэлд машин, тоног төхөөрөмжид 3 нэрийн 3982.8 мянга, тавилгад 10 нэрийн 4175.0 мянга, программ хангамжид 275.0 мянган төгрөгийн нярвын программ, аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүйгээр орон нутгийн хөрөнгө оруулалтаар 24970.0 мянган төгрөгийн үнэтэй Hiase маркийн автомашин нийт дүнгээрээ 33402.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Hiase маркийн 1 суудлын автомашиныг аймгийн ЗДТГ тендер зарлаж, "Ган тэт деволопмент ХХК-ийг шалгаруулж, худалдан авч нийлүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 488684.1 мянган төгрөг болж 116770.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 116770.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 826232.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 146078.6 мянган төгрөгөөр буюу 21.5 хувиар өссөн байна.

Үүнд орон нутгийн санхүүжилтийн орлого 1000.0 мянга, тусгай зориулалтын шилжүүлэг 137557.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 17767.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Нийт үйл ажиллагааны зардал 706481,6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 69505.6 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал 40521.9 мянга, хангамжийн зардал 10509.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 7670.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байр ашиглалтын тогтмол зардал 64.5 мянга, эд хогшил урсгал засварын зардал 343.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1141.4 мянга төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг 711280.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 711280.0 мянган төгрөг, орон тоо 25 байхаар хийж хүргүүлсэн байна.

2020 оны төсөв 649549.3 мянган төгрөгөөр буюу 61730.7 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна.

Тайлант онд дээрх төсөвт 1 удаа зохицуулалт хийж, байр ашиглалтын тогтмол зардлаас 1000.0 мянган төгрөг бууруулж, 648549.3 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 649549.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж 1 удаа тодотгол хийн 648549.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 634506.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 14043.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 14043.3 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 634506.6 мянга, нийт 648549.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 644606.3 мянган төгрөгийг зарцуулж 3943.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 644606.3 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 1951.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 189.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 1718.1 мянга, албан томилолтын зардлыг 5000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 256.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.7 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 10.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 72207 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 2078.5 мянга, 80109 арга хэмжээ 1718.3 мянга, 80802 арга хэмжээ 10.1 мянга, 81815 арга хэмжээ 136.2 мянган төгрөгөөр тус тус дутуу хэмнэсэнтэй холбоотой байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
НИЙТ ДҮН	648,549.3	644,606.3	3,943.0	99.4
ХӨТӨЛБӨР 72207				-
АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагаа	161,258.7	159,180.2	2,078.5	98.7
АРГА ХЭМЖЭЭ 80109 ТШЗ-ын тогтмол зардал	14,043.3	12,325.0	1,718.3	87.8
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	600.0	589.9	10.1	98.3
АРГА ХЭМЖЭЭ 83115 Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр	472,647.3	472,511.1	136.2	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	648,549.3	644,615.3	3,934.0	99.4
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	634,506.0	632,290.2	2,215.8	99.7
Орон нутгийн төсвөөс	14,043.3	12,325.0	1,718.3	87.8

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 149806.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, 131745.4 зарцуулж, 18061.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Д.Д	Үзүүлэлт	орлого	зарлага	зөрүү
1	Зуслангийн орлого	35,767.0	35,736.8	30.2
2	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ	2,700.0	2,700.0	-
3	НҮБ-ын санхүүжилт, зарцуулалт	93,186.6	75,155.3	18,031.3
4	Аймгийн ЗДТГ-аас олгосон санхүүжилт, зарцуулалт	13,000.0	13,000.0	-
5	Аймгийн ЗДТГ-аас нийгмийн ажилтан Э.Үүртуяагийн цалин, НДШ	2,816.8	2,816.8	-
6	Аймгийн ИТХ-аас олгосон мөнгө, зарцуулалт	916.5	916.5	-
7	ХНХЯ-аас ирсэн сургалтын санхүүжилт, зарцуулалт	1,000.0	1,000.0	-
8	Тендерийн хураамж	420.0	420.0	-
9	төвлөрүүлсэн		18,061.5	(18,061.5)
	Нийт дүн	149,806.9	149,806.9	-

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаанд нь 126 мэдээлэл оруулж, 225678.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тайлант онд худалдан авсан 9995,0 мянган төгрөгийн үнэ бүхий УАЗ маркийн 04-21БНХ улсын дугаартай автомашины гэрчилгээ иргэн П.Баттулгын нэр дээр байгаа зөрчил илэрч зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн бөгөөд хуулийн байгууллагад шилжүүлж хаагдсан байна

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайланд алдаа, зөрчил илрээгүй, шилэн дансны сайтад мэдээлэл дутуу, зарим мэдээллийг байршуулаагүй байх тул зөвлөмж өгөв. /Хавсралт 1./

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд 51754.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, шилэн дансны мэдээлэл байршуулахтай холбоотой 1, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 2, нийт 3 зөвлөмж өглөө.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Санхүүгийн тайланд хийсэн аудитын хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд хийгдсэн 149806.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг аудитын сорилоор нарийвчлан шалгаагүй тул дараагийн аудитаар анхаарч авах үзэх шаардлагатай байна. Тухайлбал: Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сантай 2017-2021 онд хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний дагуу 2020 онд 93186.6 мянган төгрөгийн санхүүжилт авч "Хамтдаа шийдье" төслийн хүрээнд 16000 өрхөд сургалт сурталчилгааны материал 46400,0 мянган төгрөгөөр хэвлүүлсэн бөгөөд зарим нь хэвлэлтээс дутуу ирсэн байхад хөрөнгийн орлогод бүрэн бүртгэсэн байна. Мөн хүүхэд хамгааллын зардлаас 7980,0 мянган төгрөгөөр 3 гэр худалдан авч орлогоор бүртгэсэн бөгөөд тайлант онд зарлага гаргаагүй байна. Энэ нь орон гэргүй болсон зорилтот бүлгийн гэр бүлд зориулагдсан бөгөөд оны дараа олгогдсон гэсэн тайлбарыг нягтлан бодогч Л.Батнасан өгч байна. Иймд нэмэлт санхүүжилтийн дансны орлого түүний зарцуулалтыг дараагийн завсрын аудитын нарийвчлан үзэх шаардлага гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд аймагт шинээр баригдаж буй хуримын ордныг түшиглэн "Хуримын хүндэтгэлийн өргөө", "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв", "Гэмт хэрэгт холбогдсон буюу хохирогч хүүхдээс мэдүүлэг авах өрөө" байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Ямаат өндөр хайрхан" ХХК-д 49900.0 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд хөрөнгийг орлого аваагүй тул балансад авлагаар тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт, "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл: Хөрөнгө үрэгдэх, шамшигдах.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт хэрэгжүүлж, санхүүгийн тайланд өр, авлага үүсгэхгүй ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаанд нь 126 мэдээлэл оруулж, 225678.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, байгаа нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

2.2. Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1669105 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 165055.7 мянган төгрөг буюу 1854.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. НББ-ийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.4 “**ҮНЭН ЗӨВ БАЙХ**”, 13-р зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, **санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах..**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн дахин үнэлгээний журналын бичилтийг байдлын тайлангийн дахин үнэлгээтэй тохируулж, журналын бичилтийг 1854.8 мянган төгрөгөөр залруулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25



5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			БНА-2021/50/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаанд нь 126 мэдээлэл оруулж, 225678.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Мэндбаяр, Л.Батнасан
2	Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1669105 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд 165055.7 мянган төгрөг буюу 1854.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1854.8	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Мэндбаяр, Л.Батнасан
3	Тайлант онд аймагт шинээр баригдаж буй хуримын ордныг түшиглэн “Хуримын хүндэтгэлийн өргөө”, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”, “Гэмт хэрэгт холбогдсон буюу хохирогч хүүхдээс мэдүүлэг авах өрөө” байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэхээр шалгарсан “Ямаат өндөр хайрхан” ХХК-д 49900.0 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд хөрөнгийг орлого аваагүй тул балансад авлагаар тусгасан байна.	49900.0	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Мэндбаяр, Л.Батнасан
ДҮН		51754.8			

оОо